

Худалдаа, үйлчилгээний байгууллагуудын
ажиллах цагийн хуваарийг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 "ж", 29.2, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3 дахь хэсэг, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2010 оны 198 дугаар тогтоолоор батлагдсан "Нийслэлийн худалдаа, үйлчилгээний нийтлэг журам"-ын 1.7-д заасныг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нийслэлд худалдаа, үйлчилгээ эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллагуудын ажил эхлэх, дуусах цагийн хуваарийг нэгдүгээр, шөнийн цэнгээний газрын ажиллах цагийн хуваарийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Нийслэлийн хэмжээнд худалдаа, үйлчилгээний байгууллагуудын ажиллах цагийн хуваарьт хавсралтын дагуу өөрчлөлт оруулж 2013 оны 06 дугаар сарын 03-ны өдрөөс мөрдөж, зохион байгуулалтын арга хэмжээ авахыг аж ахуйн нэгж, байгууллагуудын удирдлагуудад, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллахыг нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар /М.Ням -Очир/, нийслэлийн Цагдаагийн газар /Д.Батжаргал/, дүүргийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар хангаж, хяналт тавьж ажиллахыг Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба /Б.Бадрал/-нд, олон нийтэд хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчлахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл, мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтэс /Б.Түвшинтөгс/-т тус тус үүрэг болгосугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ

Э.БАТ-ҮҮЛ

Нийслэлийн Засаг даргын 2013 оны
05 дугаар сарын 30-ны өдрийн
А/548 дугаар захирамжийн 1 дүгээр
хавсралт

НИЙСЛЭЛИЙН ХЭМЖЭЭНД ХУДАЛДАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
БАЙГУУЛЛАГУУДЫН АЖИЛЛАХ ЦАГИЙН ХУВААРЬ

д/д	Худалдаа үйлчилгээний цэгийн төрөл	Ажиллах цаг /өвлийн улиралд/		Ажиллах цаг /зуны улиралд/	
1	Нийтийн үйлчилгээтэй цайны газар	09.00	20.00	08.00	22.00
2	Хүнсний мухлаг	09.00	22.00	08.00	22.00
3	Аж үйлдвэрийн барааны дэлгүүр	10.00	20.00	09.00	21.00
4	Албан байгууллагуудын дэргэдэх цайны газрууд	Байгууллагын ажиллах цагийн хуваарьт зохицож ажиллана.			
5	Банк, эмийн сан, шатахуун түгээгүүрийн станц	24 цагаар үйлчилгээ эрхэлж болно. /Нэгдсэн 1 төрлийн эмблемтэй хаягтай байна./			
6	Түргэн үйлчилгээтэй сүлжээ хоолны газрууд	Өглөөний 07.00 - шөнийн 03.00 цагт үйлчилж болно.			

Нийслэлийн Засаг даргын 2013 оны
05 дугаар сарын 30-ны өдрийн
А/548 дугаар захирамжийн 2 дугаар
хавсралт

ШӨНИЙН ЦЭНГЭЭНИЙ ГАЗРЫН АЖИЛЛАХ
ЦАГИЙН ХУВААРЬ

№	Худалдаа үйлчилгээний цэгийн төрөл	Ажиллах цаг
1	Шөнийн цэнгээний газар /Тусгай хөтөлбөрт үйлчилгээтэй диско, бүжиг, шоу үзүүлбэртэй гэх мэт/ Пүрэв, Баасан, Бямба гаригт	Шөнийн 00.00 цагаас хойш согтууруулах ундаагаар үйлчлэхгүйгээр 03.00 цаг хүртэл үйлчилж болно.
2	Бусад гаригт	15.00 -00.00 цагт үйлчилнэ

Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх зөвшөөрөлтэй худалдаа, үйлчилгээний газарт 00-06 цагт Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.8 дахь хэсгийг баримтлан ажиллах.